



**МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ**

2022 оны 02 сарын 09 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Хүсэлтийн тухай

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Ганзориг даргалж, Танхимын тэргүүн Г.Алтанчимэг, Ч.Хосбаяр, Ч.Тунгалаг, шүүгч Б.Амарбаясгалан, Г.Банзрагч, Х.Батсүрэн, С.Батдэлгэр, Б.Батцэрэн, П.Золзаяа, Д.Мөнхтуяа, П.Соёл-Эрдэнэ, С.Соёмбо-Эрдэнэ, Б.Цогт, Ц.Цогт, Д.Эрдэнэбалсүрэн, Х.Эрдэнэсүвд нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар,

Үндсэн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг бүртгүүлэх тухай хүсэлтийг шүүгч Х.Батсүрэнгийн танилцуулснаар хянан хэлэлцээд

ТОДОРХОЙЛОХ нь:

Хүсэлт гаргагч Ардчилсан намын тэргүүн дэд дарга гэх Д.Ганбатаас 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 259 дүгээр албан бичгээр тус шүүхэд ирүүлсэн хүсэлтдээ: “Улс төрийн намын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т “Намын Их Хурлаар батлагдсан намын дүрэм, мөрийн хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт оруулах сонгогдсон бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах асуудлыг намын төлөөллийн төв байгууллага шийдвэрлэж болно” гэж заасны дагуу Ардчилсан намын Үндсэн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг бүртгүүлэхээр Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 30 дугаар тогтоолд заасан зөрчлийг арилган хүргүүлж байна. Дүрмийн нэмэлт өөрчлөлтийг Үндэсний Бодлогын хороо “цаашид ҮБХ гэх”-ны ээлжит бус 2021 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн хуралдааны 07 дугаар тогтоолоор баталсан болно. Хүсэлтдээ улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдлийн маягт, гэрчилгээний хуулбар, өргөдлийн хавсралт, Ардчилсан намын ҮБХ-ны 2021 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн ээлжит бус хуралдааны хурлын 07 дугаар тогтоол, уг хуралдааны хурлын 01 дүгээр тэмдэглэл, тус өдрийн цахим хурлын ирцийн мэдээлэл, ... зэрэг баримтуудыг хавсарган холбогдох хууль тогтоомжийн дагуу бүртгэж өгнө үү” гэжээ.

ҮНДЭСЛЭХ нь:

Улс төрийн намын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т “Дараахь асуудлыг зөвхөн намын Их Хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ”; 13.2.1-д “намын дүрэм, мөрийн хөтөлбөрийг батлах”, 13.4-т “Намын Их Хурлаар батлагдсан намын дүрэм, мөрийн хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт оруулах, сонгогдсон бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах асуудлыг намын төлөөллийн төв байгууллага шийдвэрлэж болно” гэж заажээ.

Ардчилсан намын Үндсэн дүрмийн 5.13.12.15-д “Төрийн сонгуулийн хууль өөрчлөгдсөн тохиолдолд намын Их Хурал зарлан хуралдуулах цаг хугацааны боломжгүй үед ҮБХ-ны нийт гишүүдийн 2/3-ын саналаар намын Үндсэн дүрэмд зөвхөн уг асуудлаар нэмэлт өөрчлөлт оруулах” гэж заасан, тухайн тохиолдолд уг заалтад заасан урьдчилсан нөхцөл үүсээгүй буюу төрийн сонгуулийн хууль өөрчлөгдөж, цаг хугацааны хувьд Их Хурал хуралдах боломжгүй тохиолдол үүсээгүй тул дүрмийн энэ зохицуулалт хэрэглэгдэхгүй.

Мөн Үндсэн дүрмийн 5.13.12.27-д “ҮБХ нь намын Үндсэн дүрэмд нийцүүлэн дараах журмуудыг баталж, мөрдүүлнэ. Үүнд: 5.13.12.27.6.Намын Үзэл баримтлал, Үндсэн дүрэм, бусад журамд нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчилсэн найруулга хийх, өргөн барих, батлуулах тухай” гэж зааснаар ҮБХ нь зөвхөн намын ... Үндсэн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах журам батлах эрхтэй, харин намын Үндсэн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах эрхгүй байна.

Түүнчлэн Үндсэн дүрмийн 9.1.1-д “Намын ... үндсэн дүрэм ...-д нэмэлт өөрчлөлт оруулах ... асуудлыг ҮБХ-ны Үзэл баримтлал, Үндсэн дүрмийн Зөвлөлийн саналд үндэслэн ҮБХ-ноос намын Их Хуралд өргөн барина” гэснээс үзэхэд намын Үндсэн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг ҮБХ нь бие даан шийдвэрлэх боломжгүй.

Иймд, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1-д заасны дагуу Үндэсний бодлогын хорооны 2021 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн ээлжит бус хуралдааны хурлаас баталсан Үндсэн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэхээс татгалзах нь зүйтэй гэж Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаас үзлээ.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.8, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1-д заасныг тус тус удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Ардчилсан намын Үндэсний Бодлогын хорооны 2021 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн ээлжит бус хуралдааны хурлын 07 дугаар тогтоолоор оруулсан Ардчилсан намын Үндсэн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэхээс татгалзсугай.

2.Хүсэлт гаргагчаас улсын тэмдэгтийн хураамжид төлсөн 150 000 /нэг зуун тавин мянган/ төгрөгийг улсын орлогод хэвээр үлдээсүгэй.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ

ИЛТГЭГЧ ШҮҮГЧ

Х.БАТСҮРЭН